



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД
ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2015.08.29 № 05/14877
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төсөл, хөтөлбөр, гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ядамдоржийн Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын зам, тээвэр, цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал хариуцсан Засгийн газрын референтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Авсайн Мөнхбат, Монгол Улсын шадар сайдын ажлын албаны шинжээчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Санжаасүрэнгийн Амаржаргал, Жаргалсайханы Хулан нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигчид нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

Харин Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төсөл, хөтөлбөр, гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлийн удирдлага хариуцсан Засгийн газрын референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ядамдоржийн Жавхлангийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим системд бүртгэж баталгаажуулаагүй байх тул хянан үзэх боломжгүй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР

Н.ДАМДИНСҮРЭН



142503010575

